



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТҮМТЭД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.31 № 02А-2020/04-НА-ЗР
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намын Сэлэнгэ аймаг дахь түмтийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын Хувьсгалт намын Сэлэнгэ аймаг дахь түмт нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

Монгол Ардын Хувьсгалт намын Сэлэнгэ аймаг дахь түмтийн Сэлэнгэ аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол Ардын Хувьсгалт намын Сэлэнгэ аймаг дахь түмтийн мөрийн хөтөлбөр /...3... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон сумдын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМАГ БОЛОН СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
ХУВЬСГАЛТ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



**ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ “ЭРҮҮЛ МОНГОЛ”
ХӨТӨЛБӨР**

Зорилго

“МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ” нам нь Сэлэнгэ аймгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн бүр эрүүл аюулгүй амьдрах эрхийг дээдэлж Эрх бүрд орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэн жил бүр тодорхой хэмжээний өрхийг орон сууцаар хангах,
- Сэлэнгэ аймгийн залуучуудаа төр засгийн зардлаар дээд боловсрол олгож, нарийн мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ,
- Сэлэнгэ аймгийн иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төрийн өмчийн эмнэлгээр үйлчлүүлэхэд төр засгаас бүрэн хариуцаж иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх,
- Иргэдээ ажлын байраар хангах, орлогын найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх,
- Ядууралд өртсөн иргэдээ “Хүрэлцэхүйц орлого”-той болгох, ядуурлыг бүрмөсөн арилгахад хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах,
- Төр засгийн бүх шатны байгууллагуудыг авилгаас ангид байлгах,

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж, Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжих бодлого баримтална.


“МАХН” нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харьяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй эрүүл орчинд амьдран, сурч боловсрох эрхтэй.

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахын эсрэг байр суурьтай ажиллана.

- 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд амьдрах хэмжээнд хүрэхүйц баталгаатай орлоготой болгох санал санаачилга гаргаж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- Жирэмсэн эмэгтэйчүүд, 3-5 насны хүүхэдтэй ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого баримтална.
- “Монгол хүн-Оюунлаг иргэд”-ийг төлөвшүүлэх зорилгоор хүүхэд бүр амьдралын түвшнээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон их дээд сургуульд суралцах тэгш боломжийг бүрдүүлж ажиллана.
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Иргэн бүр дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, технологи бүхий эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хэвшүүлэх нөхцөл бололцоогоор хангах зорилго тавин ажиллана.



ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:


Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймгийн төв болон суурин газарт амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

- Аймгийн төв, сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллана.
- Иргэдийн насанд тохирсон бичил болон өрхийн бизнесийг дэмжих чиглэлээр зөвлөх үйлчилгээг үзүүлэх төвүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран бий болгоно.

ГУРАВ. СУМДАД:

- Сумдын агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлэн ажиллана.
- Бизнес эрхлэгч залуучуудад зориулсан гарааны бизнесийг дэмжих “Старт апп” хөтөлбөрийг хэрэгжүүлж сум бүрд дундын оффис байгуулах бодлого баримтална.
- Аймаг болон сумын төвүүдэд жил бүр 200 гарааны бизнес эрхлэх иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан уян хатан ажиллах ажлын байр олноор бий болгох зорилт тавин ажиллана.

- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажиллуулах санаачилгыг дэмжин, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих бодлого баримтална.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилаг, сэргээн засах төвийг байгуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- Аймаг, сум, орон нутгийн гол ус бүхий ногоон орчинд иргэдийн оролцоотой “Байгальд ээлтэй эко аймаг” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчныг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Аймаг, сумын төвүүдэд төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубүүд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүдэд чөлөөтэй олгох болон тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана.
- Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн болон малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана.
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох чиглэлээр малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлнэ.
- Сумдад “Цагаан алт” болох ноос, арьс шир боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг бодлогоор дэмжин ажиллана.
- Алслагдсан сумдын бэлчээрийг худаг усаар хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аймаг, сумын засаг даргын дэргэд “Багш” сан байгуулж ажиллуулах боломжийг судлан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Аймаг, сумын Засаг даргыг иргэд шууд сонгодог болох саналыг холбогдох байгууллагад уламжилна.



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТҮМТ

